

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД, САНГИЙН САЙД, ТӨРИЙН ӨМЧИЙН
БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2023 оны 08 дугаар сарын 18 өдөр Дугаар А/67 Улаанбаатар хот

**Сургуулийн зориулалттай барилгын талбай
түрээслэх жишиг үнийн дээд хязгаар тогтоох тухай**

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 234 дүгээр тогтоолын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлд сургуулийн зориулалтаар барилгын талбай түрээслэхэд 1 метр квадрат талбайн түрээслэх үнийн дээд хязгаарыг 45,000.0 төгрөгөөр тогтоосугай.
2. Энэ тушаалын нэгд заасан үнийн дээд хязгаарт багтаан түрээслүүлэгчтэй хэлэлцээ хийн холбогдох хууль, журмын хүрээнд гэрээ байгуулах, зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Нийслэлийн боловсролын газар, холбогдох төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар /Т.Ням-Очир/-т даалгасугай.

БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

ТӨРИЙН ӨМЧИЙН
БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ